

**Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГазарт 2025 оны 1-р улирлын
иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын
шийдвэрлэлтийн тайлан**

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны 1-р улирлын тайлан, мэдээг танилцуулж байна.

Тайлант хугацаанд манай байгууллагад радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн дамжуулалтын ашиглалт, үйлчилгээтэй холбоотойгоор хэрэглэгчийн 85 гомдол, хүсэлт утсаар ирүүлсний 78% нь телевиз гарахгүй, 15% нь радио сонсогдохгүй үлдсэн 5% нь сувгийн тохиргоо заалгах зэрэг хүсэлт ирсэн байна. “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн хугацааг баримтлан иргэдийн хүсэлтийг 100 хувь шийдвэрлэн ажилласан. Үүнийг шалтгаанаар авч үзвэл:

- Хэрэглэгчийн төхөөрөмжийн холболт, чанар болон тохиргоотой холбоотой гомдол, хүсэлт 38%-ийг
- Дамжуулах байгууламжийн гэмтэл саатал, үзлэг үйлчилгээний талаарх гомдол, хүсэлт 53%-ийг
- Шугамын радиогийн хураамжтай холбоотой хүсэлт 8%-ийг
- Гадны хүн байгууллагын үйл ажиллагааны талаарх гомдол, хүсэлт 1%-ийг тус бүр эзэлсэн байна.

2025 оны 1-р улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон үзүүлэлтийг өмнөх оны 1-р улиралтай харьцуулахад хэвийн байна. Цаашид дамжуулалтын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой хүсэлтийг бууруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг төлөвлөгөөнд тусган, ажиллаж байна.

- Телевизийн өргөн нэвтрүүлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, найдвартай, тасалдалгүй ажиллагааны бэлэн байдлыг нэмэгдүүлэх;

- Улаанбаатар хотын хэмжээнд ашиглагдаж буй аналогич радио станцыг тоон технологич шилжүүлэх;
- Телевизийн төхөөрөмжийн тохиргооны заавар бичлэгийг нийтэд хүртээмжтэй байдлаар түгээх, сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Хот орчмын сайтуудыг алсын зайны хяналтын системтэй болгох.